



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1127

Булган

Г Гэрээ шууд байгуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын үерийн сувгийн даланг шинэчлэн засварлах ажлыг Улаанбаатар хотын "Энх шилтгээн" ХХК-тай 76 300 000 /далан зургаан сая гурван зуун мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/-д олгосугай.


2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль, тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэлд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Гэрээний хугацаанд ажлыг холбогдох хууль, дүрэм, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Энх шилтгээн" ХХК /Т.Өсөхбаяр/-д даалгасугай.

4. Гэрээнд заасан ажлын санхүүжилтийг гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны а/139 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ